



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/442

Мөрөн сум

Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд
оролцох албан хаагчийг урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.4, 4.1 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 16 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гал унтраах техникийн олон төрөлт спортын Дэлхийн аварга шалгаруулах 18 дахь удаагийн тэмцээн 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөс 9 дүгээр сарын 06-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Турк улсын Станбул хотод зохион байгуулагдана. Тус тэмцээнд Монгол Улсыг төлөөлөн Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын Цагаан-Уул сум дахь Гал түймэр унтраах, аврах 76 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч Х.Чүлтэм оролцох болсон тул Олон улсын болон Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож байгаа тамирчинд нэг удаагийн 500.000 (Таван зуун мянган) төгрөгийн урамшуулахыг Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэхийг Засаг даргын тамгын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч Б.Батбилгүүнд зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

671 0010003